



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 01 дугаар сарын 05

№ 07/01

Улаанбаатар хот

АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА ДЭД ХУРАНДАА ТАНАА

Комисс нь 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт байрлах " " ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой жагсаал, цуглаан хийсэн иргэд, малчдын 14 төлөөллийг хүлээн авч уулзан, хүний эрхийн зөвлөгөө өгсөн болно.

Үүний дараа Комисс аймгийн сумын багийн төвд иргэд, малчдын 2022 оны 09 дүгээр сарын 14-18-ны өдрийг хүртэл зохион байгуулсан жагсаал, цуглааны үйл явцыг анхааралтай ажиглан, баримтжуулалт хийх явцад ХХК-ийн хамгаалалтын албаны ажилтнууд болон иргэд, малчдын дунд зөрчил, маргаан үүссэн тул тэдний аюулгүй байдлыг хангах, шаардлагатай арга хэмжээг шуурхай авхуулахаар аймгийн Цагдаагийн газрын удирдлагуудтай холбогдон ажилласан.

Комисст хандаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/361 дүгээр болон 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/448 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээллийн дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу ажиллагаа хийв. Энэ хүрээнд Комиссын ажлын хэсэг Дундговь аймгийн Өлзийт суманд 2022 оны 12 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд ажиллан, "Гурвансайхан" ХХК-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, тус компанийн зарим ажилтнууд аймаг, сумын удирдлагууд, иргэд, малчдын төлөөлөлтэй уулзан, шаардлагатай баримт, мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

- сумын багт " " ХХК-ийн үйл ажиллагааг эсэргүүцэн зохион байгуулсан жагсаал, цуглаантай холбоотойгоор аймгийн Цагдаагийн газарт 7 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 3-т нь хэрэг бүртгэх ажиллагаа явуулан, 1-д нь эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн бол 3-т нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлсэн байна.
- аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсээс 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хайгуулын өрөмдлөгөөс гарсан тос тосолгооны шингэн болон өтгөн лаг шаврыг зориулалтын бус газар асгаж, хөрс бохирдуулсан асуудалд шалгалт хийн, "Эрдэнэдриллинг" ХХК, "Цагаан суварга дриллинг" ХХК, "Орд Гео" ХХК тус бүрт Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасны дагуу Хог хаягдлын тухай хуулийг зөрчсөн гэж үзэж, 3.000.000 (гурван сая) төгрөгөөр торгосон байна. Түүнчлэн эдгээр компаниуд нь Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд хайгуулын үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нэмж тусгах, шингэн хог хаягдлыг бүртгэлжүүлэх, бүртгэлийн тайланд тусгаж хэвших, аюултай хог хаягдалд үүсгэгчид БОАЖЯ-наас

бүртгэлийн дугаар авах талаар эрх бүхий албан тушаалтны даалгаврыг хүргүүлсэн байна.

- Комисст ирүүлсэн Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 2/730 дугаар албан бичигт “Дундговь аймгийн Өлзийт сумын иргэд, малчид Ашигт малтмал, газрын тосны газраас МҮ-020629 дугаарын тусгай зөвшөөрлийг “Гурвансайхан” ХХК-д олгосон 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 509 дүгээр тушаалыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр гаргасныг шүүх хүлээн авч, 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 128/ШЗ2022/10431 дугаарын захиргааны хэрэг үүсгэсэн байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулах, хариу тайлбар авах шатандаа байгаа бөгөөд эцэслэн шийдэгдээгүй талаар дурджээ.

Үүнээс үзэхэд “Гурвансайхан” ХХК болон иргэд, малчдын хооронд үүссэн зөрчил, маргааны асуудал шүүх болон хуулийн байгууллагуудаар шалгагдаж байгаа бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Комисс мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахгүй” гэж заасны дагуу шүүхийн процесс үргэлжилж байгаа тохиолдолд Комисс оролцох боломжгүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтад “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй...” гэж Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1948 оны 217/A/III/ дугаар тогтоолоор баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана”, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” болохыг тунхагласан.

Энэхүү эрх нь Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 21 дүгээр зүйлээр баталгаажиг хамгаалагдсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын оролцогч улсууд нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүхэлд нь хүндэтгэн сахих хууль зүйн үүрэгтэй болно.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэн жагсаал, цуглаан зохион байгуулах эрхтэй бөгөөд мөн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхах”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд жагсаал, цуглаан хийхэд зориуд саад учруулах, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тараах”-ыг тус тус хориглосон.

Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасныг үндэслэн цаашид иргэд, малчид тайван замаар үзэл бодлоо илэрхийлж байгаа үед холбогдох хууль тогтоомжид заасан журам, хэм хэмжээг

мөрдөх, эмх замбараагүй байдал үүсгэхгүй, хүний эрхийн зөрчил гаргахгүй байх чиглэлээр Комиссын гишүүний дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Жагсаал, цуглааны үеэр эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд цагдаагийн байгууллагаас албадан тараахдаа сөргөлдөөнд хүргэж болзошгүй нөхцөл байдал, эрсдэлийг бууруулахыг эрмэлзэх, хүч хэрэглэх тохиолдолд заавал жагсагчдад урьдчилан анхааруулж, сануулах; Мөн тухайн нөхцөл байдалд тохирсон хамгийн бага хүчийг хэрэглэхийг эрмэлзэх;
- Тайван, эсэргүүцэл үзүүлээгүй, шаардлага биелүүлж байгаа жагсагчийг саатуулах нь хүний эрхийн зөрчил болохыг анхаарч, зөвхөн гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллийн шинжтэй үйлдэл гаргасан этгээдэд хүч, албадлага хэрэглэх;
- Жагсаал, цуглааны үеэр хүүхэд, охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг онцгой эмзэг жагсагчдад онцгой анхаарал хандуулах;
- Цагдаагийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт заасан албадан тараах ажиллагааны явцыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах, хүч хэрэглэсний улмаас хүний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдол нэг бүрийг бүртгэж анхан шатны тусламж авах боломжийг бүрдүүлэх;
- Цагдаагийн албаны тухай хуулийн 52, 54 дүгээр зүйлээр тус тус тогтоосон нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл, журмыг чанд мөрдөх. Ялангуяа олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө прокурорт мэдэгдэх, тогтоосон бүсээс даруй гарахыг шаардах, тухайн бүсэд байгаа хүнийг бүсээс гаргах талаар ухуулга хийх, хэрэглэх тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар мэдээлэх, яаралтай тусламж үзүүлэх мэргэжлийн байгууллагад тодорхой газар, байршилд ирэх тухай мэдэгдэх, анхааруулга, ухуулгыг тусгай хэрэгслийн нөлөөлөлд өртөж болох хүмүүсийн дийлэнх хэсэгт хүргэх боломжтой бүх арга хэрэгслийг ашиглан зохион байгуулах журмыг мөрдөж ажиллах;
- Хуульд заасан үндэслэлээр иргэнийг саатуулах тохиолдолд саатуулагдсан иргэнд саатуулах болсон шалтгаан, үндэслэлийг тайлбарлах, гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, ойр дотны хүнд нь даруй мэдэгдэх; Өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулж, эдлүүлэх, мэдүүлэг, тайлбар авахдаа өмгөөлөөгчийг байлцуулах, өмгөөлөгчийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;
- Эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг нь доромжлон харьцах зэрэг аливаа хууль бус үйлдлийг гаргахгүй байх;
- Саатуулагдсан иргэдэд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх, ундны цэвэр усаар хангах болон бусад хууль ёсны хүсэлт, шаардлагыг биелүүлэн ажиллах;
- Саатуулах үйл явц, хугацаанд хяналтын камерыг бүрэн ажиллагаатай байлгаж бичлэгийн хадгалалт, хамгаалалтыг тогтмол хийх;
- Иргэд, малчдыг зүгээс “Гурвансайхан” ХХК-д тавьж буй асуудлыг харилцан зөвшилцөх, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх талаар талуудад зөвлөх;

- Жагсаал, цуглааны үед хууль сахиулахад хүний эрхийг хангах талаар алба хаагчдад зориулсан сургалтыг тогтмолжуулах.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, мэдээллийг холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлэхийг мэдэгдье.

ГИШҮҮН



С.ДОНДОВ